

Олон улсын парламентын холбооны Ерөнхий нарийн бичгийн даргын мэндчилгээ

Улсын их хурлын эрхэм гишүүд ээ,

Хүндэт зочид оо,

Хатагтай, ноёд оо,

Энэхүү чухал арга хэмжээнд оролцож байгаадаа баяртай байна. Тогтвортой хөгжлийн бүх зорилтуудад бүрэн хүрсэн гэж хэлэх улс орон одоогоор байхгүй байгаагийн адилаар жендерийн тэгш байдлыг бүрэн хангасан гэж итгэлтэйгээр хэлэх улс орон одоогоор алга байна. Жендэрийн тэгш байдал болон тогтвортой хөгжлийн асуудлыг хооронд нь холбон авч үзэж, харилцан уялдаатай асуудлыг гэдгийг хүлээн зөвшөөрөх нь чухал. Энэ нь зөв чиглэлд алхам болно. Энэ хоёр зорилтыг хэрэгжүүлэхэд парламент чухал үүрэгтэй ч дангаараа хийж чадахгүй. Тиймээс би жендэрийн тэгш байдал болон тогтвортой хөгжлийн асуудлаар өргөн хүрээний хэлэцүүлгийг зохион бaейгуулж буй энэхүү санаачлагыг сайшаан дэмжиж байна.

Өнөөдөр дэлхий нийтэд тулгарч буй олон янзын сорил бэрхшээлүүд нь ажиллах арга барилаа өөрчлөхийг биднээс шаардаж байна. Дэлхийн хүн амын тэн хагасыг орхигдуулах, тулгамдсан асуудлуудаа шийдвэрлэх тал дээр олсон ололт амжилтаа ухрах эрх бидэнд огтоос байхгүй. Сөрөг нөлөөг даван туулах чадвартай, цочролд тэсвэртэй байхын тулд хүртээмжтэй бөгөөд хүлээн зөвшөөрөгдсөн, бат бэх, хуулийг дээдлэх зарчимд суурилсан, нийтийн эрх ашигт үйлчлэх институцууд хамгийн чухал үүргийг гүйцэтгэнэ.

Жендерийн тэгш байдал нь шударга, чинээлэг, амар амгалан нийгмийг бий болгох урьтал нөхцөл гэдэгтэй бүгд санал нийлнэ гэдэгт би итгэж байна. Жинхэнэ ардчиллыг ч мөн үүгээр илэрхийлнэ. Олон улсын парламентын холбоо жендэрийн тэгш байдлын асуудалд нэн тэргүүний ая холбогдлыг өгч ирсэн бөгөөд олон арван жилийн туршид гишүүн орнуудынхаа үндэсний парламентуудын жендэрийн тэгш байдалд анхаараад зогсохгүй тэдгээрийн үйл ажиллагаагаар дамжуулан илүү өргөн хүрээний нөлөөг үзүүлэхийг зорин ажиллаж ирсэн.

Бидэнд хийх ажил их байна. Гэсэн ч сайн сайхан өөрчлөлтүүд боломжтой гэдгийг бид мэдэж байна, мөн хэрхэн хүрэхээ ч мөн төсөөлж байгаа билээ.

Нэгдүгээрт, парламентууд болон бусад байгууллагууд жендэрийн тэгш байдлыг бүх түвшинд, шийдвэр гаргалтын бүхий л тал дээр нэвтрүүлэх. Үүнд тоо, нөлөөллийн тэгш тэнцвэртэй байдал яригдахаас гадна бүхий л хэлэлцүүлэгт жендерийн тэгш ёсны асуудлыг харгалзаж сурах явдал багтана. Сайн мэдээ гэвэл бидэнд замын зураглал байна. ОУПХ-ны гишүүд 10 жилийн өмнө жендэрийн мэдрэмжтэй парламентыг төлөвшүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран баталсан юм. ОУПХ-ын тодорхойлолтоор жендэрийн мэдрэмжтэй парламент гэж нийт суудлын тооны хувьд төдийгүй удирдах түвшинд, нийт хороодын түвшинд тэгш оролцоог хангасан парламентыг хэлдэг. Жинхэнэ хүртээмжтэйгээр, төлөөллийг бүрэн ханган ажиллахын тулд парламентууд чиг үүргийн тодорхой байдлыг хангаж үйл ажиллагаандаа жендэрийн тэгш байдлыг улам бүр хангах арга механизмуудыг бүрдүүлэн ажиллах нь чухал байна. Маш тодорхой бодлого, хэрэгжихүйц механизмууд мөн хангалттай нөөц боломжийг бүрдүүлэх явдал юм. Өнөөдөр дэлхийн 90 гаруй улс эмэгтэйчүүдийн квотыг хуульчлан тогтоосон бол жендэрийн тэгш байдлыг хуулиар хангуулан

ажиллаж буй улс орнуудын тоо улам бүр нэмэгдсээр байна. Парламентын дийлэнх танхимуудад жендэрийн тэгш байдлын хороод байгуулагдаж, эмэгтэй парламентчдын зуу гаруй бүлэг дэлхийн өнцөг булан бүрт эмэгтэйчүүдийн дуу хоолой болон ажиллаж байна. Жендэрийн мэдрэмжтэй парламент хүйсээр ялгаварлан гадуурхах, дарамтлах, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийлэх зэрэгт “үгүй” гэж хэлж чаддаг парламент байх учиртай. Үүний эсрэг хууль батлаж, бодлогоо тодорхой болгож тэгш байдлын соёлыг төлөвшүүлж буй улс орнууд улам бүр олширч байна,. Ийм бодлого парламентад ч үйлчлэх ёстой.

Хоёрдугаарт, эерэг өөрчлөлтөд хүрэх замыг баттайгаар тавихын тулд парламент болон бусад институциуд үйл ажиллагааныхаа бүхий л чиглэлд жендэрийн тэгш байдлыг зорилго болгон тавих. Хууль тогтоомж, бодлогод оршсоор буй ялгамжтай хандлагыг устган арилгах, тэгш байдлыг хангах явцыг хурдасгах хууль тогтоомжуудыг батлах явдал үүнд багтана. Хүйсээр үл ялгаварласан хуулиудыг батлах нь хангалтгүй юм. Хуульд жендэрийн тэгш байдлыг хангах зорилтууд агуулагдах нь чухал бөгөөд тэгш бус байдлыг халах оновчтой арга хэмжээг хуульд заах, ялгаварлан гадуурхах байдлаас хохирч ирсэн хүн амын бүлгийг дэмжих, соёлын болон практик саад тотгоруудыг арилгахад чиглэсэн зүйл заалтуудыг оруулах нь чухал юм. Эмэгтэйчүүдийн тэгш эрхийн асуудал, боловсрол, эдийн засгийн тэгш эрх, эрх чөлөөний асуудал хамгийн түрүүнд тавигдаж эрэгтэйчүүдтэй эн тэнцүү улс төрийн шийдвэр гаргалтад оролцох асуудал хоёрт юм хэмээх хүмүүс цөөнгүй бий. Дээрх асуудлууд нэгэн зэрэг шийдэгдэх шаардлагатай гэдгийг туршлага бидэнд харуулж байна, үлгэр дуурайл болохуйц хүчирхэг манлайлагчид, салбарт бүрт түүштай чармайлт гаргаж амжилтад хүрэх эмэгтэйчүүд асар их шаардагдаж байна. Парламентууд эрхийг хуульчлан баталгаажуулах, үндсэн хууль болон бусад хуулиудыг шинэчлэх, эрх тэгш байдлыг хангахад хөрөнгө нөөц хуваарилах, иргэдийн дуу хоолойг эрх тэгш сонсдог соёлыг төлөвшүүлэх ажлыг манлайлж чадна, манлайлах ч ёстой. Бид бүгдээрээ харахыг хүсч буй өөрчлөлтүүдээ хэрэгжүүлэх ёстой. ОУПХ нь Монгол Улсын парламент болон бусад олон парламенттай эдгээр зорилтын хүрээнд хамтран ажиллаж байгаадаа туйлын баяртай байна. Энэ хамтын ажиллагааны хүрээнд олон сайхан ажил хэрэгжинэ гэдэгт итгэж байна.